

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2013 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 1/125 А/80

Улаанбаатар хот

“Хамгаалуулагчийн эрүүл мэндийг
хамгаалах талаар төрийн тусгай хамгаалалтын байгууллага,
эрүүл мэндийн байгууллага хамтран ажиллах журам”-ыг
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 7, 9 дэх хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 -ын “ж” дэх дэд заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хамгаалуулагчийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагааг зохицуулах зорилгоор “Хамгаалуулагчийн эрүүл мэндийг хамгаалах талаар төрийн тусгай хамгаалалтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага хамтран ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (М.Оюунчимэг), Салбарын хяналтын газар (Н.Сүнчин), Улсын хоёрдугаар төв эмнэлэг (Н.Эрдэнэбулган), Төрийн тусгай хамгаалалтын газрын Хамгаалалтын төлөвлөлт, дүн шинжилгээний хэлтэс (хурандаа И.Мөнх-Амар)-т тус тус үүрэг болгосугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Төгсдэлгэр, Төрийн тусгай хамгаалалтын газрын Дэд дарга хурандаа Д.Тэмүүлэн нарт даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга нарын 2002 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хамтран баталсан “Төр, засгийн тэргүүн нарын эрүүл мэндийг хамгаалах талаар Төрийн тусгай хамгаалалтын газар, эрүүл мэндийн байгууллагууд хамтран ажиллах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ
Л.АЛТАНГЭРЭЛ



ХАМГААЛУУЛАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР
ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГА,
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн мэдээллийн нууцлалыг хангах, орчны болон хүнсний эрүүл ахуйн хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр Төрийн тусгай хамгаалалтын газар, Эрүүл мэндийн байгууллага хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцохтой холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмын эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актаас бүрдэнэ.

1.3. Энэхүү журамд заасан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. "хамгаалуулагч" гэж Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасныг;

1.3.2. "эмнэлгийн тусламж, үйлчилгээ" гэж Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг.

1.3.3. "томилогдсон эмч, сувилагч" гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал /цаашид "УИХ" гэх/-ын дарга, Ерөнхий сайд нарын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг байнга шууд гардан хариуцах эмч, сувилагчийг;

1.3.4. "хариуцагч эмч, сувилагч" гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нараас бусад хамгаалуулагч нарын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хариуцах эмч, сувилагчийг;

1.3.5. "гэр бүлийн гишүүд" гэж хамгаалуулагчтай нэг гэрт хамт амьдардаг түүний эхнэр /нөхөр/, хүүхэд, ач, зээ, эцэг, эх, хадам эцэг, эх болон бусад төрөл, садангийн хүнийг.

1.4. Төрийн тусгай хамгаалалтын газар (цаашид "ТТХГ" гэх), Эрүүл мэндийн байгууллага (цаашид "Эрүүл мэндийн яам" гэх) нь дараах чиглэлээр хамтран ажиллана:

1.4.1. хамгаалуулагчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх;

1.4.2. хамгаалуулагчийн эрүүл мэндийн мэдээллийн нууцлалыг хангах;

1.4.3. хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа орчинд болон хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх;

1.4.4. харилцан мэдээлэл солилцох.

1.5. Энэхүү журмаар зохицуулагдаагүй хамгаалуулагчийн эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой үүссэн бусад харилцааг 2 байгууллагын удирдлага тухай бүр хууль тогтоомжид нийцүүлэн хамтран шийдвэрлэнэ.

ХОЁР. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

2.1.Хамгаалуулагчид үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг Улсын хоёрдугаар төв эмнэлэг /цаашид "УХТЭ" гэх/-ийн үйл ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлнэ.

2.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нарын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг байнга шууд гардан хариуцах эмч, сувилагчийг хамгаалуулагч болон ТТХГ-тай албан ёсоор зөвшилцсөний үндсэн дээр Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилно.

2.3.Энэ журмын 2.2-т заасан хамгаалуулагч нарыг гадаад улсад зорчиход томилогдсон эмч, шаардлагатай тохиолдолд сувилагч дагалдан явах бөгөөд тухайн улсад эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажлыг ТТХГ-аас Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан хангана.

2.4.Энэ журмын 2.2-т заасан хамгаалуулагч нарыг орон нутагт зорчиход томилогдсон эмч, шаардлагатай тохиолдолд сувилагч дагалдан явах бөгөөд тухайн орон нутагт эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажлыг орон нутгийн эрүүл мэндийн байгууллага хангаж, дараах ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.4.1.Хамгаалуулагч тухайн орон нутагт байх хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх өрөө, тасалгааг тусгайлан бэлтгэж, бэлэн байдлыг хангах;

2.4.2.ТТХГ-аас тавьсан саналын дагуу олон нийтийг хамарсан арга хэмжээний үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх эмч, сувилагч, яаралтай тусламжийн автомашиныг бэлэн байлгах;

2.4.3.Энэ журмын 2.2-т зааснаас бусад хамгаалуулагч орон нутагт зорчих үед шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээг түргэн, шуурхай үзүүлэх.

2.5.Эрүүл мэндийн яам хамгаалуулагчийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг харьяа байгууллагуудыг мэргэжил аргагүйн удирдлага, зөвлөмжөөр хангана.

2.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдаар ажиллаж байсан иргэнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг УХТЭ хариуцан хэрэгжүүлэх бөгөөд хариуцагч эмч, сувилагчийг УХТЭ-ийн захирлын шийдвэрээр томилно.

2.7.УХТЭ нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.7.1.Хамгаалуулагч нарт үйлчлэх төрөлжсөн мэргэжлийн эмч, яаралтай үед зөвлөх, ажилбарт оролцох эмч, мэргэжилтнүүд, гардан хариуцаж эмчлэх эмч, сувилагчийг эзгүйд орлон ажиллах эмч, сувилагчийг сонгон судалж, Эрүүл мэндийн сайдад танилцуулна;

2.7.2.Энэ журмын 2.2-т заасан хамгаалуулагч нарт чанар, эрүүл ахуйн аюулгүй баталгаатай яаралтай тусламжийн болон бусад эм тариа, эмчилгээ, шинжилгээ оношилгооны зориулалттай багаж хэрэгсэл, шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, тусгай орц гарц бүхий өрөө тасалгааг тусгайлан гаргаж байнгын бэлэн байдалд байлгана;

2.7.3.Энэ журмын 2.2-т заасан хамгаалуулагч нарыг төрийн ёслолын арга хэмжээнд оролцох үед иж бүрэн тоноглогдсон эмнэлгийн яаралтай тусламжийн машин, жолооч, томилогдсон эмч, сувилагч нар үйлчилнэ;

2.7.4.Манай улсад айлчлал хийж буй гадаад улсын дээд хэмжээний зочныг нэгдүгээр зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад байх хугацаанд

шаардлагатай үед үйлчлэх эмнэлгийн өрөө тасалгаа бэлтгэх ба иж бүрэн тоноглогдсон яаралтай тусламжийн машин, жолооч, хариуцагч эмч, сувилагчийг айлчлалын хугацаанд тусгайлан томилж ажиллуулна;

2.7.5. Энэ журмын 2.2, 2.6-д заасан хамгаалуулагч нарыг гэр бүлийн гишүүдийн хамт жилд нэг удаа УХТЭ-ийн захирлын тушаалаар томилогдсон үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд хамруулж, үзлэгийн дүнг нэгтгэн эрүүл мэндийн дүгнэлт, цаашид авах арга хэмжээг боловсруулж Эрүүл мэндийн яаманд танилцуулан шийдвэр гаргуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна;

2.7.6. Энэ журмын 2.2, 2.6-д заасан хамгаалуулагч нарын гэр бүлийн гишүүдэд хөтлөх эмнэлгийн анхан шатны маягтыг хэвлүүлж, эмнэлгийн бүх төрлийн шинжилгээ, төрөлжсөн мэргэжлийн эмч нарын үзлэг бүрийг тодорхой бичиж, томилогдсон болон хариуцагч эмч тусгай дэвтэр, хавтаст хадгална;

2.7.7. Энэ журмын 2.2, 2.6-д заасан хамгаалуулагч нар болон тэдний гэр бүлийн гишүүдийн эмнэлгийн дүгнэлттэй шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтнүүд, УХТЭ-ийн захирал холбогдох хууль, журмын дагуу танилцуулна;

2.7.8. Хамгаалуулагчийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх шаардлагатай үед эмнэлгийн өрөө тасалгаа, эм тариа, тоног төхөөрөмж, төрөлжсөн мэргэжлийн эмч, зөвлөх эмч нарын ажлын бэлэн байдлыг хангаж, зайлшгүй хийгдэх шинжилгээ, эмчилгээг цаг алдалгүй хийнэ;

2.7.9. Хамгаалуулагч нарын хөлөглөн яваа автомашинд шаардлагатай эм, бэлдмэлийг агуулсан эмийн сан, ашиглах зааврын хамт байнгын бэлэн байдал байлгана;

2.7.10. Хамгаалуулагч нарын амь насанд аюултай нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, ТТХГ, Эрүүл мэндийн яамны холбогдох санал, зөвлөгөөнийг тусган, цаашид нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр шинэчилж байна.

2.8. Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, ажлын ачаалал даах чадвартай болон бусад шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг хамгаалуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гардан хариуцах эмч, сувилагчаар томилно.

2.9. Томилогдсон болон хариуцагч эмч, сувилагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох баталгаагаар хангагдана:

2.9.1. Хамгаалуулагчийн эрүүл мэндийг хамгаалж, шаардагдах үзлэг, шинжилгээ эмчилгээг цаг алдалгүй хийж эмнэлгийн удирдлага, ТТХГ-ын даргыг хамгаалуулагчийн эрүүл мэндийн тухай мэдээлэл, судалгаагаар хангаж ажиллана;

2.9.2. Эмч, сувилагч нь үйл ажиллагаагаа өөрийн үүргийн дагуу гүйцэтгэх ба тэдний ажлыг УХТЭ мэргэжлийн удирдлагаар хангаж, ТТХГ төрийн тусгай хамгаалалттай бүсэд зохих журмын дагуу саадгүй нэвтрүүлж, харилцан уялдаатай ажиллах боломжоор хангана;

2.9.3. Энэ журмын 2.2-т заасан хамгаалуулагчийн эрүүл мэндийн байдалд өөрчлөлт гарсан үед томилогдсон эмч нь байнгын хяналт тавьж, барих дэглэмийн талаарх зөвлөмжийг хамгаалуулагч болон түүний аюулгүй байдлыг шууд хариуцсан ТТХГ-ын шадар хамгаалалтын нэгжийн даргад өгнө;

2.9.4. Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үзлэгийн багаж, зориулалтын хувцас, тээврийн хэрэгслээр хангагдана;

2.9.5. Томилогдсон эмч, сувилагчийн ажлын ачаалал, онцлогийг харгалзан хамгаалуулагч, түүний гэр бүлийн гишүүдээс бусад хүнийг эмчлэх ажлаас чөлөөлнө;

2.9.6.Томилогдсон эмч, сувилагчийн ажлын онцгой нөхцөл, хариуцлагыг харгалзан албан тушаалын үндсэн цалинг 50 хувиас доошгүй хувиар нэмэгдүүлж болно.

2.10.ТТХГ нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.10.1.Томилогдсон эмчээс өгсөн хамгаалуулагчийн эрүүл мэндийн дэглэмийг сахиулан мөрдүүлэхэд анхаарна;

2.10.2.Энэ журмын 2.2-т заасан хамгаалуулагчийн эрүүл мэндийг гардан хариуцах эмч, сувилагчийг томилоход холбогдох судалгаа хийж Эрүүл мэндийн яаманд саналаа өгнө;

2.10.3.Томилогдсон болон хариуцагч, эмчлэгч эмч нарын өдөр тутмын ажилд хяналт тавьж, шаардлагатай үед тэдний ажлын талаар эмнэлгийн удирдлагатай ярьж зөвлөж байна;

2.10.4.Шаардлагатай гэж үзвэл хамгаалуулагчийг тээврийн хэрэгслээр зорчих үед томилогдсон болон хариуцагч эмч, сувилагч нарыг яаралтай тусламжийн машинтай хамт явуулах талаар УХТЭ-т урьдчилан мэдэгдэнэ;

2.10.5.Хамгаалуулагч нарыг эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх үед өрөө тасалгаанд инженер, техникийн болон хоол, хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдалд урьдчилсан үзлэг хийнэ;

2.10.6.Холбогдох албан хаагчдад эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлэх сургалтыг УХТЭ-тэй хамтран зохион байгуулна;

2.10.7.Ээлжийн амралтаар болон нэг сараас дээш хугацаагаар ажлаас чөлөөлөгдөж яваад ажилдаа орсон, халдварт өвчний голомт бүхий газарт байсан хамгаалалт, үйлчилгээний ажилтныг халдварт өвчний урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй оруулж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

2.10.8.Хамгаалуулагчтай шууд харьцдаг хамгаалалт, үйлчилгээний ажилтан, тэдний гэр бүлийн гишүүдэд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авна;

2.10.9.Хамгаалуулагчтай шууд харьцдаг хамгаалалт, үйлчилгээний ажилтан, тэдний гэр бүлийн гишүүдийг УХТЭ-ийн үзлэг, оношилгоонд хамруулна;

2.10.10.Хамгаалуулагчтай шууд харьцдаг хамгаалалт, үйлчилгээний ажилтан шинээр томилогдох бүрд болон жилд нэг удаа УХТЭ-т эрүүл мэндийн үзлэгт хамруулна;

2.10.11.Хамгаалуулагч нарын дунд болон тэдний ажиллаж, амьдарч буй орчинд хордлого, халдвар гарсан тохиолдолд Эрүүл мэндийн яаманд мэдэгдэж, тархварын судалгаа хийж холбогдох арга хэмжээг авна.

ГУРАВ. ХАМГААЛУУЛАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАНГАХ

3.1.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5.ж-д зааснаар хуулиар төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлээр хамгаалуулж байгаа хамгаалуулагчийн эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл нь төрийн нууцад хамаарна.

3.2.Энэ журмын 3.1-д заасан төрийн нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хангах, задруулахгүй байх нөхцөлийг Эрүүл мэндийн яам, ТТХГ, УХТЭ болон бусад албан тушаалтан төрийн нууцыг хамгаалахтай холбоотой нийтлэг журмын дагуу бүрдүүлж хэрэгжүүлнэ.

3.3.Энэ журмын 2.2-т заасан хамгаалуулагч нарын эрүүл мэндийн дүгнэлт нь нууцын зэрэглэлд багтах бөгөөд уг материалтай Эрүүл мэндийн сайд, ТТХГ-ын

дарга болон энэ журамд заасан холбогдох бусад албан тушаалтан зохих журмын дагуу танилцана.

3.4.Төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлд хамаарахаас бусад хамгаалуулагчийн эрүүл мэндийн байдлын мэдээлэл нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалагдана.

3.5.Томилогдсон эмч, сувилагч албан ажлын дагуу олж мэдсэн ТТХГ-ын төрийн тусгай хамгаалалт, үйлчилгээний төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг задруулахгүй байх нууцын баталгааг бичгээр өгнө.

ДӨРӨВ. ХАМГААЛУУЛАГЧИЙН АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БАЙГАА ОРЧИНД БОЛОН ХЭРЭГЛЭХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНД ЭРҮҮЛ АХУЙН ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

4.1.Хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа орчинд болон хэрэглэх хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хөндлөнгийн хяналт /цаашид "эрүүл ахуйн хяналт" гэх/-г Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар /цаашид "Салбарын хяналтын газар" гэх/ хариуцна.

4.2.Эрүүл ахуйн хяналтыг ТТХГ-аас ирүүлсэн албан хүсэлтэд дурдсан хамгаалуулагчийн ажиллах объектын орчны болон хэрэглэх хүнсний аюулгүй байдалд нэгдсэн болон хэсэгчилсэн хяналт шалгалт явуулах байдлаар зохион байгуулна.

4.3.Салбарын хяналтын газар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1.ТТХГ-аас нэрсийг нь гаргаж өгсөн объектуудын орчин, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийж, шаардлагатай тохиолдолд шинжилгээтэй урьдчилан сэргийлэх хяналтыг тавьж дүнг албан бичгээр хүргүүлэх;

4.3.2.Хяналт шалгалтаар ноцтой зөрчил илэрвэл ТТХГ-т тухай бүр шуурхай мэдэгдэнэ;

4.3.3.ТТХГ-аас ирүүлсэн саналыг үндэслэн хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, норм, стандарт зэргийг зөрчсөн асуудлыг шалган хариу өгнө;

4.3.4.Улаанбаатар хотын ус, хөрс, агаарын бохирдол, аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ болон холбогдох аж ахуйн нэгжүүдэд хийсэн хяналт шалгалтын эрсдэлийн үнэлгээг жилд 1 удаа, шаардлагатай бол тухай бүр ТТХГ-т мэдэгдэнэ;

4.3.5.Чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан импортын болон дотоодын хүнсний талаарх мэдээллийг тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран жилд 1 удаа ТТХГ-т гарган өгч, онцлон анхаарах асуудал үүссэн тохиолдолд яаралтай мэдэгдэнэ;

4.3.6.ТТХГ-ын эрүүл ахуйч эмч, хүнсний эрүүл ахуй аюулгүй байдлын чиглэлээр ажиллах ажилтанд мэргэшүүлэх чиглэлийн зохих мэдлэг олгох, тэднийг дадлагажуулах чиглэлд сургалтад хамруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллана.

4.4.ТТХГ нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1.Хамгаалуулагч нарын ажиллаж амьдарч байгаа газрууд болон төрийн тусгай хамгаалалтад байх барилга, объект болон бусад зүйлд эрүүл ахуйн хяналт тавина;

4.4.2.Хамгаалуулагч нарын албан тасалгаа, өргөө, зориулалтын орон сууцны агаар болон усанд улирал тутам батлагдсан хуваарийн дагуу орчны иж

бүрэн шинжилгээг салбарын хяналтын холбогдох байгууллагаар хийлгүүлэн хамтран ажиллана;

4.4.3.Төрийн тусгай хамгаалалт байнга зохион байгуулагддаг болон хяналт тавьж ажиллах объектуудын жагсаалтыг гарган Салбарын хяналтын газарт өгч, тэдгээрийн эрүүл ахуйн шаардлагад нийцсэн эсэх талаарх мэдээллийг авч хамтран ажиллана;

4.4.4.Хамгаалуулагч нарыг орчны болон хүнсний бүтээгдэхүүнээс шалтгаалсан хоолны хордлогот өвчин, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хоол хүнсийг хангах, бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх бүх шатанд эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг баримталж байгаа эсэхэд хяналт тавьж, хүнсэнд хэрэглэхийг хориглох хүртэл арга хэмжээг авч ажиллана;

4.4.5.ТТХГ-ын эрүүл ахуйч эмч нар объектод очиж ажиллах үед эрүүл ахуйн шаардлага хангаагүй тохиолдолд Салбарын хяналтын газарт мэдэгдэн, улсын байцаагч нартай хамтран хяналт тавьж, хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд ба шууд бусаар хор хохирол учруулж болзошгүй нөхцөл байдлыг тогтоож, хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлүүлэхгүй, тухайн арга хэмжээнд оролцуулахгүй байх тухай мэдээллийг Төрийн ёслолын асуудал эрхэлсэн байгууллага болон хамгаалалтын эрх бүхий албан тушаалтанд яаралтай мэдэгдэнэ.

ТАВ. ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

5.1.Энэ журмын 2.2, 2.6-д заасан хамгаалуулагч гадаад оронд болон орон нутагт зорчих үед тухайн улс, орон нутагт гардаг олон улсын хөл хориот болон бусад халдварт өвчний тухай мэдээлэл, түүнээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг томилогдсон, хариуцагч эмчээс ТТХГ-т өгч холбогдох арга хэмжээг авна.

5.2.Эрүүл мэндийн яам олон улсын хөл хориот болон бусад халдварт өвчний тухай мэдээлэл, судалгааг ТТХГ-ын хүсэлтийн дагуу албан ёсоор гаргаж өгнө.

5.3.ТТХГ энэ журмын 2.2-т заасан хамгаалуулагч нарын орчны болон хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ТТХГ-т хийсэн шинжилгээний холбогдох мэдээллийг Эрүүл мэндийн яамны хүсэлтээр өгч болно.

5.4.ТТХГ энэ журмын 2.2-т заасан хамгаалуулагч орон нутагт зорчих үед түүний эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой мэдээллийг албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

5.5.Энэ журмын 5.4-т заасан ажиллагааг цаг хугацааны хувьд хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд ТТХГ-ын хамгаалалтын төлөвлөлт хариуцсан нэгжийн дарга Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын даргад утсаар шуурхай мэдэгдэн холбогдох арга хэмжээг авхуулж, албан бичгийг нөхөж явуулна.

5.6.ТТХГ хамгаалуулагч нар Улаанбаатар хотод арга хэмжээнд оролцох болон орон нутагт зорчих үед эрүүл ахуйн хяналт хэрэгжүүлэх чиглэлээр Салбарын хяналтын газарт зохион байгуулагдах арга хэмжээний тухай болон хамтран ажиллах зарчим, оролцох хүч хэрэгсэл, шаардлагатай бусад асуудлын талаар албан ёсоор мэдэгдэж хамтран ажиллана.